

МОНГОЛЫН УЛС ТӨРИЙН СОЁЛ: ЁС ЗҮЙН ХЭМЖЭЭС**Ё. Довчин** доктор, профессор

МУИС, НШУС, Улс төр судлалын тэнхмийн эрхлэгч

Түлхүүр үг: чиг баримжаа, хандлага, ардчилал, элит, оролцоо, хариуцлага.

Товч утга: Эл өгүүлэлд ёс зүй бол улстөрийн соёлын чухал бүрэлдхүүн элемент учраас монголчуудын улстөрийн соёлын онцлогийг уул асуудалтай холбож авч үзсэн. Монголын улстөрийн соёл ардчиллын жилүүдэд шинэчлэгдэн өөрчлөгдсөөр байгаа хэдий ч түүний ямарч нийгэмд мөрдөгдөх ёстой суурь үнэт зүйлс нь хэвээр оршиж иргэдийн улстөрийн хандлага, чиг баримжааг тодорхойлсоор байна. Үүнтэй холбогдуулан өнөөгийн эрх баригч элитийн улстөрийн үйл байдлыг улстөрийн соёлын хандлагын үүднээс ёс зүйн шалгуураар авч үзэхэд анхаарал төвлөрүүлж зарим үнэлэлт дүгнэлт өгсөн болно.

Эртний Грекийн суут гүн ухаантан Аристотель ёс зүй бол улс төрийн онолын удиртгал, оршил болж зайлшгүй шаардагдана гээд хүнийг хүн болгодог гол чанар бол ёс суртхууны ухамсар гэсэн санааг хэлснээс хойш олон зуун жил улиран одсон ч энэ нь хүн төрөлхтний хамтын амьдралын хийгээд онол-судалгааны мөнхийн сэдэв хэвээр байгаа ажээ. XX зууны 90-ээд оноос шинэ зам сонгосон Монголын улстөрийн системийн хөгжил, тогтвортой байдал, иргэдийн ухамсар нь ардчилсан улстөрийн соёлын төлөвлөс шууд хамаарна. Иймд эл өгүүлэлд улстөрийн амьдралын субъектив талыг тусгадаг улстөрийн соёлыг онолын үндэс, өнөөгийн монголын нийгэм-улстөрийн амьдралын баримтуудад тулгуурлан ёс зүйн хэмжүүрээр цэгнэн үзэхийг зорьсон болно.

Аливаа үндэстний улстөрийн ертөнцийн тухай төсөөлөл, итгэл үнэмшил, үнэт зүйлс, өөрийн улстөрийн систем, төр засагтаа хандах чиг баримжаануудын нийлбэр цогц гэж улстөрийн соёлыг хураангуйлан томъёолж болох юм. Улстөрийн соёл үндэстний соёлын нэг хэсэг нь болох учраас тухайн ард түмний түүхэн уламжлал, домог, шашин, ёс заншил, хууль эрх, бэлгэ тэмдэг тэргүүтэн түүний дотоод бүтцийн бүрдвэрүүд болж байдаг. Монголын улстөрийн соёл ч ийм байх нь зүйн хэрэг. Гэхдээ уг соёл дорнын уламжлал, нүүдлийн соёл иргэншлийн түүхэн онцлогтой уялдан өрнийн суурин иргэншлийн соёлоос өвөрмөц шинжээрээ ялгардаг.¹ Тал нутгийн нүүдэлчдийн байгал, түүх, аж төрөх ёс, ёс заншил, ертөнцийг үзэх үзлээс гарвалтай тэдний улстөрийн төсөөлөл, итгэл үнэмшил, үнэт зүйлс төлөвшиж бий болсон нь лавтай. Монголчуудын эртнээс хаан эзнээ тэнгэр язгууртай, ард олныг хошуучлан манлайлахаар заяагдсан хэмээн үздэг төрөө шүтэн дээдлэхүй нь тэдний улстөрийн соёлын

тулгуур үнэт зүйл болсоор иржээ. "Төрийн сүлд минь өршөө" хэмээн залбирдаг нь тэдний төрд хандах хандлага, улстөрийн үйл байдлын шинж төлөв, утга учрыг илэрхийлдэг.

Монгол үндэстэн түүхийн зуун зууны нугачааг туулан өөрийн гэсэн төр ёсыг бий болгохдоо төрийг хүчирхийллийн, эсвэл ашиг арилжааны хэрэгсэл гэж тооцдоггүй харин ч авран хамгаалагч, шударга үнэний биет цогцлол хэмээн хүлээн авч, тэр дундаа хүчтэй, төвлөрсөн төрийг илүүтэй эрхэмлэж байсан нь нүүдлийн ахуйгаас улбаатай байгал газар зүйн хийгээд ах зах, ихэс дээдэс, ёс жудагаа хүндэтгэн дагадаг нийгэм-соёлын хүчин зүйлсээр нөхцөлдөж байсныг гэрчилдэг. Төрдөө үнэнч зүтгэх үйлс хэн бүхний ариун үүрэг гэдэг нь монгол хүний дотоод итгэл үнэмшил болж үүргийн соёлыг бий болгосоныг түүхэн эх сурвалжуудаас мэдэж болно.

Ер нь монголчуудын хувьд улстөр гагц засгийн эрхийн төлөө тэмцэл төдий биш бөгөөд улстөр бол хүмүүн нийгэм зохион байгуулагдах жам ёсны тухай гүн ухаан, даган мөрдөх үнэт зүйлс, бишрэн тэмүүлэх чин хүслэнгийн тухай цогц үзэл байжээ. Нэг үгээр энэ бүхнийг товчлон хураангуйлагч тэнгэрийн үзэл нь улстөр, төрийн тухай үзэл сургаалийн иш үндэс болж байв.

Монголын уламжлалт улстөрийн соёлд нүүдлийн аж төрөх ёсноос улбаатай айлсан нөхөрлөх, мал ахуйгаа хамтран эрхлэх, харилцан туслах гэх мэт "айл хүний амь нэг" гэсэн хамтын шинж түлхүү тусч, бүлгийн явцуу ашиг сонирхлоор хуваагдан тэмцэлдэхээс хүний ёс, эрхэмлэл, үнэт зүйлсийг урьдал болгож, бусдын төлөө үзлийг амиа хичээхээс, үүрэг хариуцлагыг эрх ямбаас дээгүүр тавьдаг нь түүнд онцгой нөлөөтэй байв. Түүнчлэн домог, шашин, бэлэгдэл ёс улстөрийн төсөөлөлд нь арилшгүй ул мөр үлдээсэн байдаг. Монголчуудын улстөрийн соёл бүхэлдээ ёс зүй-үнэт зүйлсийн чиг баримжааг цөм болгож, ёс суртхуун хийгээд хууль эрх нь ниигмийн харилцааг зохицуулах үүргээрээ нэг зиндаанд тавигдаж, өөрөөр хэлбэл ёс зүй нь хуулийн хүчтэй байсан гэж хэлж болох юм. Эв эеийг хичээх нь монголын улстөрийн соёлын түлхүүр үнэт зүйлсийн нэг мөн. Монгол хүн маргалдах сөргөлдөх, эвдрэлцэхийг уруудаж доройтохын цондон хэмээж, төр түмний хэргийг эв зүйгээр, уужуу тайвуу ухаан зарж шийдэхийг эрхэм болгодог. Түүхийн хүнд бэрх цагт чингэж хандаж байсан жишээ олон бий.² Монголын төр ёсны нэг онцлог нь нийгэмд дэг журам тогтоохыг төр нэн тэргүүний үүргээ гэж үзэхийн хамт үүний эхлэх цэг нь гадаадын нэгэн зохиолчын бичсэнээр монголчуудын эхийн сүүтэйгээ хамт хөхсөн төмөр мэт сахилга байсан³ агаад үүний хүчээр монгол төрийн суу залиг дэлхий дахинаа бишрүүлж байсан нь түүхэн үнэн юм. Монголчууд үүргийг эрхээс, эрх чөлөө, дэг журмыг эн тэнцүү чухалчлан ирсэн заншилтай.

Улстөрийн соёлын үнэт зүйлс, уламжлал, хэм хэмжээ нь харьцангуй тогтвортой байдаг онцлогтой ч бас огт өрчлөгддөггүй зүйл бас биш. Шинэ үйл явдлууд, амьдралын шинэ хэв маяг хүний үзэл бодол, түүний дотор улстөрийн хандлага, төсөөлөл, итгэл үнэмшлийг өөрчилнө. Энэ утгаар монголчуудын улстөрийн соёл түүхийн турш хувьсан өөрчлөгдсөөр ирсэн нь зайлбаргүй.

Тухайлбал, үндсэн агуулгыг нь өрнөжилт тодорхойлдог дэлхийн бүс нутгуудыг нэлэнхүйд нь нөмөрсөн өнгөрсөн зууны модернчлах үйл явцаас Монгол хоцроогүй. Иймд “өрнөжих” (westernization) нь бидний хувьд гэнэтийн шинэ үзэгдэл биш юм. Монгол улс хорьдугаар зууны туршид “орчин үежих” үйл явцыг, түүний дотор улстөрийн модернизацийг тойроогүй, дайрсан. Марксизм ч, социализм ч барууны бүтээгдхүүн, өнөөгийн ардчилал ч мөн л тэндхийнх. Өнөөдөр нийгмийн шинжлэх ухааны парадигмын шилжилтийн тухай мундахгүй ярьж, бичиж байгаа хэдий ч уг чанартаа бид өрнөжих үйл явцын гортиг дотор л эргэлдэж байгаа. Өнгөрсөн далан жилд өрнөжих үйл явцын нэг үеийг алдаа, оноотой туулсан бол ардчилалд шилжсэн он жилүүдээс хоёр дахь үе эхэлсэн гэж болно. Эл хоёр үе хоорондоо зарчмын ялгаатай нь илэрхий бөгөөд түүний дотор хоёр дахь үе хэдийгээр өрнийн үнэт зүйлсийг “шүтэж “байгаа ч үндэсний ухамсар, соёлын сэргэлт түүнтэй хүчтэй “өрсөлдөгч”-ийн байр суурь эзлэх болсон нь бас онцлог билээ.

Ер нь “модернизаци” (modernization) гэдэг нь ихэвчлэн уламжлалт нийгмээс орчин үеийн нийгэмд шилжих үйл явц, “ардчиллах үйл явц” (democratization) нь улстөрийн нэг дэглэмээс нөгөөд шилжих шилжилт гэж зааглан үздэгтэй санал нийлж байгаа ч улстөрийн байгуулал, улстөрийн соёл талаас даяаршсан уг хоёр үйл явц өрнөдийг баримжаалсан учраас ерөнхий утгаараа “орчин үежих” үзэл санаа гэж ойлгож байгаа болно.

Иймээс монголын хөгжлийн сүүлийн 20 жилийн “орчин үежих” үйл явцын агуулгыг ардчилал илэрхийлдэг. Эл үеийн гол ололт нь ямар ч атугай бидний улстөрийн сонголт буруу байгаагүй гэдэгт, түүгээр ч барахгүй ардчилал өөрийн үнэт зүйлсээр *легитимжих* болсонд оршино. Үүнийг монголчуудын улстөрийн нийгэмшлийн өнөөгийн төлөв байдал илтгэх бөгөөд энэ нь хувь хүн, хэсэг бүлэг, нийгмийн төвшинд улстөрийн чиг баримжаа, үйл байдлын динамик өөрчлөлт, улстөрийн соёлын олон хэв маягуудын харилцан үйлчлэл, зөрчил мөргөлдөөний үр дүнгээр тодорхойлогдож байна. Гэхдээ улстөрийн соёл ардчилагдан өөрчлөгдөхөд ард түмний амьжиргааны төвшин огт хамааралгүй гэвэл эндүүрэл бөгөөд харин ч хүний хөгжил, эдийн засгийн өсөлт суурь дэвсгэр болж өгөх учиртай.

Өөр өөр нийгмүүд ардчиллын өөр өөр замыг сонгож авдаг, үр дагавар нь ч бас өөр байдаг. Үүний цаад учир нь үндэсний соёл, түүний дотор улстөрийн соёлын өөрчлөлттэй холбоотойг эрдэмтэд тэмдэглэсээр ирсэн.⁴ Соёл бол зөвхөн түүхийн өв, уламжлалын тухай төсөөлөл биш. Соёл нийгэмшлийг олж авч буй хувь хүн бүрт “сууж” өгч түүний салшгүй шинж чанар болсон байдгаараа онцгой юм. Иймээс хувь хүнийг өөрчлөх нь асар “үнэ өртөг” шаарддагыг психоанализ нэгэнт нотолсон учир соёлын өөрчлөлт нь үнэхээр зовиур, зүдгүүртэй үйл явц байдаг ажгуу. Монголчууд бид ч сайхь замыг тойрохгүй нь ойлгомжтой. Энэ үүднээс өнгөрснөө цухас сөхөж, өнөөгөө зэрвэс харахыг оролдоё.

90-ээд оны эхээр нийгэм-эдийн засгийн хуримтлагдсан асуудлууд, хүнд сурталт тогтолцоо, удирдлагын арга барилыг шүүмжлэх, ил тод байдлыг бүх хүрээнд хэвшүүлэхээс эх авсан иргэдийн улстөрийн идэвхийн урьд хожид үзэгдээгүй өрнөл сөрөг хүчин, чөлөөт хэвлэл, нам, эвсэл холбоо, жагсаал цуглаан, өлсгөлөн, суулт гэх зэрэг улстөрийн оролцоо, үйл байдлын шинэ шинэ хэлбэрүүдээр дамжин оргил цэгтээ хүрэв. Энэ бүхэн улстөрийн хэвшмэл ойлголт, төсөөллийг эвдэж, улстөр гэдэг бол "алс холын" хийсвэр зүйл биш, харин нийгмийн гишүүдийн өдөр тутмын амьдрал, ашиг сонирхолтой шууд холбоотой, түүнийг гагцхүү өөрсдөө л өөрчлөх ёстойг сая сэнхрэн ухаарч хүн бүрт шахам улстөрийн үйл явдалд оролцох, өөрийн үзэл бодол, байр сууриа илэрхийлэх эрмэлзэл, мэдрэмж төрүүлсэн нь улстөрийн чиг баримжаа, үйл байдалд эргэлтийн шинжтэй өөрчлөлт гарахад нөлөөлсөн. Монголын нийгэмд анх түрүүн төр, иргэний нийгэм хэрэг дээрээ зааглагдаж, улмаар Улс төрийн товчооны огцролт, дээд удирдлагаар хаягласан хурц шүүмжлэл монголчуудын хэзээнээс засаг, эрх мэдлийг гол төлөв "зэрэг зиндаа" хэмээн үзэж⁵, түүнд тэр бүр "халддаггүй" уламжлалыг "ганхуулж", эх орон, төр хийгээд тухайн улстөрийн дэглэм, төр ба төржсөн намыг ялгаж ойлгох сэдэл болсон юм. Түүнчлэн нийгмийн янз бүрийн бүлэг, давхаргууд ашиг сонирхлоо чөлөөтэй илэрхийлж нэгтгэх үйл явц зохион байгуулалтад орж ноёрхогч үзэл суртлыг анх удаа сорилтод "дуудсан" нь улстөрийн гүнзгий үр дагавартай байв. Энэ бүхэн эрх баригч элитийг дэлхийн хөгжлийн хандлага, нийгмийн бодит ахуйгаа ул суурьтай эрэгцүүлж тунгаахад хүргэсэн нь үнэн.

Олон түмэн огцом улстөржиж, зарим хэсэг хэт хувьсгалчирхснаас болж улстөрийн тэмцэл улам бүр сэтгэл хөдлөл, хөөрлийн гүн тийш яргасаар байсан эгзэгтэй мөчид монголчуудын уламжлалт улстөрийн соёлын үнэт зүйлс тухайлбал, эв эеэ хичээх, төр ёсоо бодох, хүлээцтэй, уужуу тайвуу монгол ухаанаар хандах зэрэг нь уг үйл явцыг тогтоон барьж зөв голидролоор нь явуулахад чухал хүчин зүйл болж байв. Үүний нэг баталгаа нь засгийн эрх мэдэл улстөрийн нэг хүчнээс нөгөөд тайван замаар шилжиж чадаж байсанд оршино. Хүн амын ихэнхийн улстөрийн тэмүүлэл харьцангуй тогтвортой байсан нь "улстөрийг зохих хүрээнд барихад"⁶ дөхөм болж байв. "Ардын эрх" сонины 1990 оны 244-рт нийтлэгдсэн санал асуулгын дүнгээс үзэхэд "Та улстөрийн нам, хүчнүүдээс зохион байгуулж буй арга хэмжээнд байнга оролцдог уу?" гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 13 хувь нь тийм, 46,7 хувь нь хааяа, 37,3 хувь нь оролцдоггүй гэж хариулсан байдаг. Дээр дурдсан баримтууд эрүүл саруул ухаан, ёс суртхууны үнэлэмж соёл болгонд байдаг ч манай үндэсний соёлд түлхүү байдгийг нэг талаар гэрчлэх бизээ. А.Тойнби, "Нүүдэлчид хэрэв өөртөө зөн мэдэл, өөрийгөө эзэмдэх тэвчээр, бие махбодийн хийгээд ёс суртхууны хатыг суулгаагүйсэн бол тал нутгийг эрхшээлдээ оруулж, байгалийн тийм хатуу ширүүн орчныг тэсч гарч чадахгүй байсан биз" хэмээн бичсэн нь бий⁷.

Үүний сацуу тал нутгийнхны омог бардам, туйлшрамтгай, дарвиж дууриадаг чанар улстөрийн дүрэлзсэн "гал" дээр тос нэмж, "конвенциаль" бус

оролцооны хэлбэрүүд, үйл байдлуудыг ч “оруулж” ирэх болсныг дурдахгүй өнгөрч болохгүй. Тухайлбал, удирдлагаа огцруулах, өөрчлөх кампани бүх шатанд өрнөж ажил хаялт, суулт, өлсгөлөн, өргөх бичиг нэг үе "моод", шалгарсан арга болж байв. 1990-1991 онд аймаг хотын гүйцэтгэх захиргааны дарга нарын тэн хагасаас илүү нь, дөнгөж сонгогдоод байсан сумдын гүйцэтгэх захиргааны дарга нарын 80 хувь нь өөрчлөгдөж байжээ⁸. Эдгээрийн үр дагавар нь төрийн байгууллагын ажлыг бүх төвшинд саармагжуулж, үүний хажуугаар ардчилал, эрх чөлөөг хэн юу хүссэнээ хийж болох мэт ойлголт газар авч нийгэмд сахилга, дэг журам алдагдаж эдгээр нь "засаглалын хомсдол" гэж нэрлэгдэв.

Энэ бүхэн төр, дэглэм хоёрыг хутган ойлгосноос ихэнхдээ шалтгаалж, монголчуудын төрөө шүтэж дээдлэх үзэлд сүрхий сэв суулгасан юм. Иймээс төрөө хүндэтгэдэг ёсыг улстөрийн учир холбогдлоор адлаж шоовдорлох нь олигтой үр дүнд хүргэхгүй гэдгийг амьдрал харуулсаар бөлгөө. Түүний үндэс гүн байдаг нь олон зуун жилийн туршид монголчуудын аж төрөх ёс, байгаль, түүх, нийгэм-сэтгэл зүй, зан заншлын бодит ахуйгаар нөхцөлдөн үүсвэрлэж, уламжлагдаж ирсэнтэй холбогдоно. Ахмад үе, ах дүүсээ харилцан хүндэтгэх сэтгэл, хамтач, нийтэч аж төрөх сэтгэл, зан суртхуун нь нийгмийн харилцаанд хүчтэй нөлөөлж, зохицуулж байсан нь төр тогтвортой, дээдлэн хүндлэгдэж байх ниймийн шалтгаан, хүчин зүйл байсан⁸ гэдэг нь үнэн юм.

90-ээд онд монголчуудын улстөрийн зан араншин бараг үндсээ хүртэл ил гарсан гэж хэлж болно. Энэ байдал дунд ардчилалд нийцэж тохирох үйл байдлын хэв загварууд байхад үл нийцэх нь ч бас байв. Жагсаал цуглаан, өлсгөлөн, ажил хаялт, огцруулалт, нам эвсэл холбоо, сүм хийд, мэрэг төлөгчид, уул овооны тахилга мэтийн эрээн мяраан үйл явдал, үзэл, итгэл бишрэл, зан үйл нь нэг талаас хүмүүсийн улстөрийн идэвх, олон ургальч үзэл, ашиг сонирхлын ялгаралтай холбоотой байсан боловч нөгөө талаас талын нүүдэлчдийн сэтгэлгээний аливаад туйлшрамтгай, дур зоргоороо байхыг илүүд үздэг хатуу хэвийг (стереотип) ямар нэг хэмжээгээр уудлан гаргасан юм. Хүний эрх, эрх чөлөө л гэсэн бол захирах захирагдах ёс, хууль дүрэм, ерөөс алив засаглал, удирдлага, зохион байгуулалтыг үгүйсгэх, хүнд сурталт тогтолцооны төржсөн намыг шүүмжилсэн бол ерөөс намаас дайжиж цэрвэх, жанжлагч үзэл суртлыг халсан бол ерөөс аливаа "изм"-үүд хэрэггүй гэх мэт аяглах нь туйлшрал, төөрөгдөл байв. Ямарч атугай "Хэрэв бид хэт туйлшралд автагдаагүйсэн бол жинхэнэ ардчиллын үр шимийг хүртэж, өнөөгийнхөөс олон дахин илүү амжилтад хүрэх байлаа"⁹ гэсэнтэй санал нийлэхээс аргагүй болсон. Түүнчлэн хүмүүс дуу дуугаа авалцан гарч ирсэн олон намуудын санал зөрөлдөөн, парламентын эх адаггүй маргаан мэтгэлцээн, тэр ч атугай нэг намаас нөгөө рүү "гүйгчдэд" хүртэл таатай биш хандаж байсан нь аливаа зөрчил сөргөлдөөнийг задрал бутралын дохио хэмээдэг, төр, шашин үндсээсээ урван тэрслэхийг цээрлэж ирсэн мөнөөх үндэсний сэтгэлгээний хатуу хэвтэй холбон тайлбарлаж болох биз ээ.

Дурдсан үйл байдал нэг талаас өрнийн нийгэм ихэнхдээ иргэний нийгэм, зах зээлд тулгуурлаж байдаг бол дорно дахинд төрийн үйлдвэрлэлийн арга давуутай байдаг зүй тогтлыг тэр бүр анзаарч үзээгүй, нөгөө талаас зах зээлийн хийгээд этатист улстөрийн соёлын хоорондын зөрчлөөс улбаатай байв. Улстөрийн эрс өөрчлөлт, эдийн засгийн уналт хүмүүсийн амьжиргаанд хүнд цохилт болов. 1996 онд Философи социологийн хүрээлэнгээс явуулсан судалгаагаар зах зээлийн шилжилт амьдралд нь сайн нөлөөлөөгүй гэсэн хүмүүсийн тоо 1991-1996 онуудад 23,3-78,7 хувь болтлоо өссөн байдаг. Гэхдээ энэ нь иргэд өөрчлөлтийн эсрэг байсан гэсэн хэрэг биш бөгөөд харин ардчилал, зах зээл ахуй амьдралыг нь нүд ирмэх зуур диваажин болгох “шидэт саваа” биш гэдгийг ухамсарлаж, тэдний адгасан хүлээлт аажмаар бодит хөрсөн дээр бууж ирсэнтэй холбож тайлбарлах нь илүү нийцтэй байх. Нийгмийн гишүүдийн ихэнх амьжиргааны төвшин буурсан хэдий ч өөрчлөлт шинэчлэлээс нүүр буруулаагүйн нэг илрэл нь 1996 онд ардчилал, зах зээлийн чамгүй радикал шинжтэй хөтөлбөр дэвшүүлсэн улстөрийн шинэ хүчинд сонгогчдын олонхи саналаа өгсөн явдал юм. Ийнхүү ардчилсан үзэл санаа иргэдийн ухамсарт өөрийн гэсэн байраа эзэлж, улстөрийн соёлын зах зээлийн хэв маяг монголын нийгэмд тэрлэж эхэлснийг баримт илтгэдэг. Улстөрийн дэврүүн ааг омог аажимдаа намдуу аястай болсон нь хүмүүс улстөрөөс нэлээд “залхаж”, үүний зэрэгцээ бас зах зээлийн эдийн засагт шилжих бодит бэрхшээл, энэхүү үйл явц ба улстөрийн ардчиллыг ялгаж салгаж ойлгох хандлага бий болсных болов уу.

Удаа дараа болж өнгөрсөн ардчиллын хэмжүүр-сонгуулиудад улстөрийн хүчнүүд, иргэдийн улс төрийн чиг баримжаа, үйл байдлын өөрчлөлт тусгалаа олж байсан гэх үндэстэй. Тухайлбал, нэг онцлог нь Монголд сонгуулийн кампани бүрийн явцад олон түмний сэтгэл зүйг залсан өвөрмөц маягийн сэдээгч давалгаа бий болж, тэр нь тухайн үед энэ хүн, эсвэл тэр намыг сонгох нь зөв гэдэг рүү сонгогчдыг хөтөлдөг, энэ нь ч сонгуулийн дүнг урьдчилан таамаглах аргагүй, "савалгаатай" болгоход нөлөөлсөөр ирсэн. Жишээ нь, 1990-1993 оны сонгуулиудад "олны жишгээр" санал өгсөн гэсэн сонгогчид тогтмол 70 орчим хувийг эзэлж байжээ¹⁰. Үүний дээр "нутгийн хүү" эн тэргүүнд тавигддагыг нотлох шаардлагагүй. Энэ бүгд аливаад ихэвчлэн төрөл садан, нутаг усныхаа нийтлэгийн үнэлэмж, үйл байдлыг баримжаа болгодог нүүдэлчдийн сэтгэлгээ, мөн сэтгэл хөдлөл-сэтгэлзүйн хүчин зүйл улстөрийн соёлд нь хүчтэй, нөлөөтэй байдгаас үүдэлтэй бололтой. Үүнээс гадна аль ч талыг “гомдоохгүй” хүчний тэнцвэрийг барих сэтгэл зүй бас ажиглагдана. Парламентын эхний хоёр сонгуулийн кампанийн үеэр "Хүний хуучин нь, дээлийн шинэ нь" давалгаа хүч авч "хуучин" нам тасархай түрүүлж байсан бол 1996 оны сонгуулийн өмнө улстөрийн хүчний харьцаа хэт тэнцвэргүй болсныг ажисан учир "энэ удаад залуучуудад" гэсэн “хэл шуудан” айлаас айлд, амнаас ам дамжсаар шинэ намуудыг "супер" ялалтад хүргэв. Энэ нөхцөлд орон нутгийн болон ерөнхийлөгчийн сонгуульд тэнцвэржүүлэлт аанай л давтагдаж нөгөө хүчний ялагдлыг нөхөж санал өгөх жишээтэй. Шинэ нөхцөлд "хуучин" нам ардчилсан сонгуульд удаа дараа дийлэнх олонхийн санал авсан нь эхний үед нийгмийн донсолгоо,бужигнаан дунд сонгогчид "хүний хуучин нь" гэсэн сэдлээр

туршлагатай, “занг нь мэдэх” намдаа нааштай хандснаас, мөн “хайрт нам засаг”-аа гэх улстөрийн чиг баримжаа ч дэм болсных бизээ. Түүнчлэн МАХН-ын өнгөрсөн түүх улс орны тусгаар тогтнол, хөгжил цэцэглэлтэй сүлжилдэн хүмүүсийн санаа сэтгэлд тод ул мөр үлдээсэн, улстөрийн ээдрээтэй нөхцөлд үндэсний эв нэгдлийг эрхэмлэн улстөрийн тэвчээр зааж дангаар эрх барих байр сууринаасаа татгалзан шинэ хүчнүүдэд найр тавьсан, мөн нийгмийн баримжаатай төрийн зохицуулалтын бодлого барьсан нь монголчуудын сэтгэлзүйд илүүтэй нийцсэн байж болох талтай. Харин 1996 оны парламентын сонгуульд “Ардчилсан холбоо” эвсэл дуулиант ялалт байгуулсан нь шинэ намууд засгийн эрхэнд гарснаар ард түмний аж амьдралыг сайжруулах дорвитой алхамууд хийгдэх болов уу хэмээн олон түмэн горилж найдсан, мөн урьдах парламентад хүчний харьцаа хэт тэнцвэргүй болж нэг намын ноёрхолд хүргэж болзошгүй гэсэн болгоомжлол сонгогчдод нөлөөлсөн зэрэгтэй холбодог нь оргүй биш.

Түүнчлэн шинэ намууд сонгуулийн хөтөлбөр, тактикаа оновчтой боловсруулж шаргуу ажилласан нь илэрхий байдаг. Уг сонгууль сонгогчид өөрсдийн талархдаг улстөрийн хүчнээ бүх тохиолдолд мухар сохроор дэмждэг үеэ өнгөрөөсөн зуршлаа орхиж байгаа нь улстөрийн нийгэмшлийн нэг онцлог гэдгийг харуулсан бол дараачийн УИХ-ын сонгууль ард түмний элч төлөөлөгчид ёс зүйн шалгуур, сонгогчдын итгэлийг дааж эс чадваас тэд ардчилсан аргаар хариуцлага тооцож болдогыг нотолсон гэж болно. Үүнтэй холбогдуулан тэмдэглэхэд аливаа төр засаг хууль ёсоор ардчилсан зарчмаар байгуулагдах нь нэг хэрэг, харин дараа нь засаглалын легитимээ хадгалж чадаж байна уу гэдэг нь гол шалгуур болдог. Тэгвэл ардчиллын жилүүдэд монголын төр улстөрийн ноёрхлын легитим шинжээ тэр бүр тогтвортой хадгалж чадахгүй байлаа. Монголд эдүгээ улстөрийн харьцангуй тайван байдлын (стабильность) талаар ярьж болохоос бус стратегийн шинжтэй тогтвортой байдал (устойчивость) бий болсон гэхэд эрт байна. Үүнд нийгэм-эдийн засгийн тулгамдсан асуудлууд, улстөрийн нөхцөл байдал нөлөөлөх нь зүйн хэрэг. Үүний зэрэгцээ өөрчлөлтийн хурдыг эрх баригчид гүйцэхгүй байх, “амьдрах” насгүй хууль, шийдвэр батлах, эсвэл парламентын хэлэлцүүлэг нэрээр намууд, улстөрчид явцуу сонирхлоороо хоосон маргалдан цаг алдаж, шийдвэр гацаадаг (ийм зан араншин аймаг, сум, дүүргийн хурлынханд “халдварласан”) зэрэг нь шууд нөлөөлдөг ч бас улстөрийн элитийн ёс зүйгээс шууд хамаарч ирсэн гэж үзэх үндэстэй. Бидэнд ардчилсан процедур хэрэгтэй, тэр ч атугай санал зөрөлдөөн нь шударга ёсны нэг нөхцөл байдаг ч бас урагшлахаа, ард ард түмэн хүлээж байгааг бодолцох ёстой. Монголчууд дээр үеэс төрийг хувь хүнчлэн ойлгож ирсэн. Иймд улстөрчийн хувийн чанар, ёс суртхуун нийтэд хамааралтай болж, ажил үйл нь зөв, шударга байхыг түүнээс хүлээж байдаг гэсэн үг юм. Улстөрчдийн хувийн ашиг сонирхол энэ зарчмаас гаждагаас болж засаглалын легитим алдагдаж, улмаар иргэд төрийн институтүүдэд эгдүүцэн дургүйцэх нь нэмэгдэх төлөвтэй байна. Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх засаглал, улстөрийн намуудад итгэх олон нийтийн итгэл улам буурах хандлагатайг судалгаануудын дүнгээс харж болно.

Сонгуулиуд нэг талаараа өнөөгийн нийгэмд бугшсан шударга бус явдал, улстөрийн луйвар, авилгал, ёс суртхууны уналт, ядуурал гэх мэт нэн хор уршигтай үзэгдлүүдийн тусгал болсоор ирсэн гэхэд хилсдэхгүй. Сонгууль чөлөөтэй, шударга байх зарчмыг баримталдаггүйгээс манайд улстөрийн шударга өрсөлдөөн алга. 2008 оны сонгуулийн дүн, түүний дараахь үймээн самууныг ардчилал, хүний эрх монголд биеллээ олж буйн жишээ гэж яавч магтан дуулах аргагүй. Уг үйлдэл тухайн үедээ “давшилт” байсан ч хэрэг дээрээ ардчиллын ухралт байв. “Зорилго нь аргаа зөвтгөнө” гэлтэй биш. Ардчилал, парламентат ёсны утга учрыг ухварлах, зөвшилцөх, хамтран ажиллах, харилцан ойлголцох соёл, улстөрийн оролцооны институтжилд олигтой ахиц гараагүйг хэрэг явдал гэрчлэв. Улстөрийн намууд, “аутсайдарууд” ардчилсан институтийг манипулятив зорилгоор ашиглах, хөөрсөн түмний хийрхэл дээр “тоглох”- оос буцахгүйг харуулав. Үүргийг товойлгодог монгол уламжлал гээгдэж, эрх үүргийн нэгдэл, өөрийн эрх бусдын эрхээр хязгаарлагддаг ардчиллын хөдөлшгүй зарчмыг тэр бүр ухварлахгүй байна. Ардчиллын сургуулиар хоёр арван жил дамжсан ч зарим хэсэг бүлэг нийгэмтэйгээ адилсаагүй, тууштай баримтлах ёс суртхууны зарчим, улстөрийн байр суурьгүй, нэг үгээр нийгмийн ямар ч ролийг биелүүлэхээс сийхгүй нь илэрхий. “Ардчилсан” иргэн ийм байж болохгүй. Эсэргүүцэл улстөр-нийгмийн учир холбогдолтой ч монголын нийгмийн бүтцийн задралаар үүссэн маргинал бүлгүүд улстөрийн зорилгоор ашиглагдах болсонтой бас холбоотой юм. Гэвч эцсийн бүлэгт улстөрийн аливаа гажуудал, бохирдлын урхаг нь ёс зүйг мартсан улстөрчидтэй шууд холбоотой. Жишээ нь, алт, ашигт малтмалын лицензи мэттэй улстөрийг хутгаж, архи, мөрийтэй тоглоомд хорхойсон, амин хувийн сонирхол нь хөндөгдвөл гудамжинд гүйн гарч хэнтэй ч сүлбэлдэж, яахаас ч үл буцах хүн “76” дотор бий. Улстөрч, олон түмэн хоёр “дотносох” нь шууд ардчиллын утгаар дэмжүүштэй мэт боловч “улстөрчид ба иргэд хоорондын ямарч зуучлалгүй шууд харилцаа нь хүмүүсийн сэтгэл хөдлөлийг далимдуулах санаархал, улмаар улстөрийн экстремизмд үүд нээж өгч байдаг”¹¹ ажээ.

Нэгэнт зах зээлийг сонгосон болохоор чөлөөт өрсөлдөөн, оролцоо, хувь хүний эрх, эрх чөлөөг хүлээн зөвшөөрөх нь зайлшгүй. Гэхдээ энэ нь нийгмийн болон хувийн бүх харилцаанд зах зээлийн хууль дангаараа ноёрхох жамтай гэсэн үг хараахан биш. Өөрөөр хэлбэл, “Хэрэв зах зээл хүний амьдралын бусад бүх хүрээг өөртөө “империалист” маягаар захирч, зөвхөн өөрийнхөө хил хязгаар дотор зөв зүйтэй байдаг иррациональ шинж, хэм хэмжээ, шалгуурыг тулган хүлээлгэх нь шударга бус” байх болно¹². Хэрэв зах зээл гол үнэт зүйлийн байрыг эзэлсэн бол нийгэм ёс суртхуунтай байж чадахгүй гэж коммунистууд үздэгийг бас анхаарахад илүүдэхгүй. Зах зээл, барууны хувь шинжийн (бодгальчлах) үзэл нийгмийн үнэт зүйлсийн системийн өөрчлөлтөд нөлөөлөх нь дамжиггүй. Гэхдээ иймэрхүү үзэл монголчуудын сэтгэлгээ, ахуй амьдралд огт байгаагүй гэвэл хэтрүүлэг болно. Гагцхүү айл саахалтынхны ойр дотно, эвсэг харьцаа, харилцан туслах, хөдөлмөрөө хоршиж хамтран ажиллах, бусдын үйл хэргийг эхлэн бүтээх, нэр төрөө бодох, нөхөрлөл түншлэлдээ үнэнч байх зэрэг төрөл садан, нутаг усаараа нэгдсэн нийтлэгүүдээрээ амьдардаг нүүдэлчдийн аж

төрөх ёсноос урган гарсан хэм хэмжээнүүдтэй шүтэлцсэн байдагаараа өрнийн бодгальчлах үзлээс ихээхэн ялгаатай төдийгүй дорнын соёлын өвөрмөц шинж - хамтач, нийтэч үзэл тийш илүү хэвийсэн байдгаараа онцлог. Иймд монголын нөхцөлд барууны бодгальчлал нь үнэт зүйл-ёс суртхуун, хэм хэмжээ давамгайлсан улстөрийн соёлтой зохирол болж байж сая улстөрийн үнэлэмж, үйл байдалд эерэг нөлөөлөх болно. Хувь үзэл, зах зээлд хэт шүтэж, түүний сөрөг үр дагавраас хүн амаа хамгаалах төрийн бодлого дутаж, нийгмийн шударга ёсыг социализмын тэгшитгэн хуваарилахтай хольж мэдэн будилснаас ядуурал нийгмийн хэмжээний үзэгдэл болж хувирсан юм.

Орчин үеийн америкийн шинэ либерализмын нэрт онолч Ж.Роулсын үзэл санаа нь зах зээлийн эдийн засгийн зарчим дээр тулгуурлаж шударга нийгмийн тогтолцоог байгуулж болохыг нотолсноороо улстөрийн философийн шинэ үеийг эхлүүлсэн билээ. Тэрбээр шударга ёс бол нийгмийн институтүүдийн анхдагч үнэт зүйл. Шударга ёсны анхдагч субъект нь нийгмийн үндсэн бүтэц буюу суурь эрх, үүргүүдийг ногдуулж, нийгмийн хамтын ажиллагаанаас үүсэх давуу талуудыг хуваарилдаг нийгмийн гол институтүүд болохыг заасан байдаг¹³. Тэгвэл манай төрийн институтүүдийн явуулсан өмч хувьчлалын алдаа завхралаас өнөөгийн нийгмийн тэгш бус байдал эх авсан. Жинхэнэ шударга нийгэм бол өөрийн хөдөлмөрөөр өмчтэй болсон, эсвэл бусдад шилжүүлсэн хүмүүсээс л бүрдэх ёстой гэж Р.Нозик бичжээ. Тэгш өрсөлдөх бололцоог хангах, баялгийг шударга хуваарилах, ажилгүйдлээс сэргийлэх алсыг харсан бодлого байсангүй. Одоо хэр сонгуулийн амлалтдаа ороогдож бэлэн мөнгө алаг цоог тараан өнөө маргаашийг аргацаахын оронд улс орны хөгжлийн тэргүүлэгч салбарууд, хүн амын эрүүл мэнд, боловсролыг хөгжүүлэх, ажлын байр бий болгоход хөрөнгө оруулалтын тууштай бодлого үгүйлэгдсээр байна. Нийгмийн халамж хавтгайрсан нь хүн амыг ядуурлаас гаргах биш харин ч бэлэнчлэхийг өөгшүүлж, бүтээлч хөдөлмөрөөс хөндийрүүлсээр ирэв.

Манай “топ” гэгдэх компаниуд шинэ технологи нэвтрүүлж эх орон, хүн ардад давын өмнө хэрэгцээтэй гадаад дотоодод найдвартай өрсөлдөхүйц бараа бүтээгдхүүн гаргахын оронд архи, тамхи үйлдвэрлэх, алт нүүрс ухах, шатхуун түгээх, наймаа хийхээс хэтрэхгүй хорин жилийг үдэв. Компаниуд ихэвчлэн гадаадын дистрибьюторын үүрэг хүлээж, үйл ажиллагаа нь мөнгө хүүлсэн шинжтэй байгаа нь нууц биш. Дээрээс нь үнэ ханш ямар байхыг төр, зах зээлийн аль нь ч биш, харин “ченжүүд” хэмээх паразит “давхарга” шийдэх болжээ. Мөн л хувийн гэж туйлширсны уршгаар улсын үйлдвэрүүд үрэн таран болж дэлхийн зах зээлд өрсөлдөх төрийн өмчит хүчирхэг компаниуд үгүйлэгдсээр өдийг хүрэв.

Өрнөдийн аж үйлдвэржсэн нийгмийн “постматериаллаг” үнэлэмжийн нөлөө манайд тусч байж болох ч улстөрөөс өгсүүлээд ахуйн хэт хээнцэр хэрэглээ, кино, дуу хөгжим, чимэглэл сурталчилгаа, чөлөөт цаг гэх мэтэд барууныг хуулбарлан дууриаж буйг улс хөгжөөд амьдрал сайжраад байна гэж хууртаж болохгүй. Гаднын бүтээгдэхүүн, үйлчилгээ, технологийг тухайн

орныхон толгойгоо зовоож, ур чадвараа шавхаж, хөлсөө дуслуулан хөдөлмөрлөж бүтээдэгийг эрхбиш ухаарах цаг болсон. Бид өөрсдөө, өөр хэн ч биш оюунаа дайчилж, гараа хөдөлгөж бүтээж чадсан цагт хөгжиж чадна. Ямар ч үнэ цэнээр болов бэлжих, хөлжих санаархалд хөтлөгдөх, зөвхөн хэрэглэх, тансаглах, биеийн жаргалыг шүтэх гедонизмд залуучууд автах болсон. Үүнийг архидалт, гэмт явдал, танхайрал, бусад ёс бус үйлдлүүд сүүдэр мэт дагалдаж байгаа нь төрөөс дэг журам тогтоох, үндэсний эрх ашиг, иргэдийнхээ аюулгүй байдлыг хангах заяагдмал үүргээ орхигдуулсны гэрч гэлтэй. Эрх зүй, ёс зүйн зохицуулалт суларсан нь хууль ёсыг үл тоох, дураар дургих, дэггүйтэх нь ердийн хэм хэмжээ мэт болж, түүнд нийтээрээ нүд дассанаас нэлээд хэсэг нь "зэрлэгших" болсныг хаацайлах аргагүй.

Монголчуудын улстөрийн соёл сэтгэл хөдлөл-мэдрэмжийн онцлог шинжээрээ ялгарч, иргэд төрөө хүндэтгэх төдийгүй түүнээс эмээж болгоомжлох мэдрэмж өндөртэй байсан нь дан ганц дорой номойн шинж гэвэл зүйд нийцэхгүй биз. Иргэн төрөөсөө "гэрэвших" нь цаад утгаараа тохиолдлын, гэнэтийн халдлага, аюулын өмнө айж түгшихээс ангижирдагаараа "улстөрийн хүн" болдог тухай санааг Гобсс хэлсэн байдаг. Гэтэл нийгэмд уул мэдрэмж үгүй болсон нь захирах захирагдах ёсны талаар буруу зөрүү ойлголт дэлгэрэхэд бас нөлөөлсөн. Өнөөдөр зарим хүмүүс ёс суртхуун, соёлын уламжлалаас өөрийгөө чөлөөтэй, айх ичих зүйлгүй мэт бодож, нийгэм, төрийн институтууд, нийтээр мөрддөг хэм хэмжээ өөрт нь падгүй мэт санах болсон нь үүний үр дагавар юм. Иймд манайд амьжиргааны ядуурлаас гадна бас хоёрдахь "ёс суртхууны ядуурал" нийгмийг хамарчээ гэхэд болно.

Нийгэм-улстөрийн үзэгдлүүдийг эргэцүүлэн тунгаахдаа монгол хүн улстөрийн соёлын суурь "инстинктээрээ" үнэт зүйл-ёс зүйн шалгуураар хэмждэг нь эргэлзээгүй. Иймээс нийгэм дэх шударга бус, ёс суртхуунгүй явдалд хүмүүс өөрсдийн амьжиргаанаас дутахгүй санаа зовж явдаг нь үүнтэй холбоотой. Юуны өмнө засаглалын тухай монголын уламжлалт сэтгэлгээ, өмнөх нийгмийн суртхууны үндэс нь шударга ёсны тухай төсөөлөл байсан бөгөөд төр засаг, эрх баригчид, улстөрийн үйл явдалд хандах хандлага, өгөх үнэлгээнд энэ нь ямагт тусгалаа олж байжээ. Өнөөдөр ч ийм байна. Нийтээр шүүмжлэн хэлэлцэх болсон шударга бус байдлын эх үүсвэр нь юуны өмнө улстөрийн орон зайг Ю.Хабермасын бичсэнээр "мөнгө ба эрх мэдэл колоничлох"¹⁴ болж үүнд эдийн засаг, төрийн захиргаа, намын элит хутгалдан орсноос үүдэлтэй. Манайд "мөнгө бол улстөр, улстөр бол мөнгө" гэсэн ойлголт нийгмийн сэтгэл зүйд хэвшиж байна гэхэд болно.

Нийт нийгмийн эрх ашгийг хамгаалах цорын ганц институт гэж болох төр өөрөө эдийн засгийн хүчтэй бүлэглэлүүдийн ашиг сонирхолд урхидуулах нь цөөнгүй. Бид бюрократ социализмын хүнд сурталт тогтолцооноос ангижирсан уу? Эл асуултад тийм гэж бардам хариулах зориг үл хүрнэ. Өнөөдөр нийгэм ардчиллагдаж байгаа гэхэд бюрократын бүх төвшинд хүнд суртал аанай л амь бөхтэй оршиж, авилгал цэцэглэх таатай орчин болсоор байгаатай маргахгүй

байх. Төрийн аппарат “Паркинсоны хуулиар” томорч, эрх баригч хүчнүүд “үндэсний эв нэгдлийг дээдлэх” нэрээр харилцан найр тавьж хичнээн олон яам, агентлаг, газар, хэлтэс, тасаг, тэдгээрийг дагуулаад хичнээн олон сайд, дэд сайд, захирал, орлогч дарга нарыг “төрүүлж” улсаас цалин хангамж, гадаад явах зардлыг нь даах болов. Үүний дээр бас “илүүдсэн” аймаг, сум өчнөөн байгаа гэх. Энэ хэмжээгээр төрийн ажил сайн болов уу гэвэл харамсалтай нь үгүй. Улаанбаатарын утааг сонгуулиас сонгуульд, даргаас дарга дамжуулан улиг болтол яривч засралыг эс олж, цаашдаа ч иргэд эрүүл мэндээ золиослох бололтой. Газрын баялаг, мөнгө, хөгжил хэмээн ам уралдан шуугицгаах хэрнээ эдгээр ажлыг амжуулах эрүүл хүн эхлээд хэрэгтэй гэдгийг агаараар амьсгалдаг хэн боловч уг нь ойлгомоорсон. Жишээ нь, 76 тэрбумыг үүнд зарахад харамсах хүн олон гарах болов уу. Түшмэдүүд ширээ сандал, хурал зөвлөгөөн, бичиг цаасаар хөөцөлдөж, ар хударгаар нь газар, ан амьтан, ой мод олз хайгчдын хүйтэн гараар орж дуусахдаа тулав. Гэмт хэрэг илрэвч хууль хяналтын олон шат дамжсаар замхарна. Хууль зөрчигчид “дээрээ татаастай”, эсвэл амьдрал ядуу гэдгээр цагаатгагдана, эсвэл өршөөгдөнө. Энэ бүхэн манайд хууль ёс, хариуцлагын ёс зүй ямархуу байгааг бэлхнээ нотолно. Үүний зэрэгцээ улсын ба хувийн, улстөрийн ба аж ахуйн ялгалгүй байгууллага нэртэй бүхэн ой тэмдэглэж найр наадамд умбан хот хөдөөгүй давхилдаж цаг, мөнгө урсгаад зогсохгүй, дээрээс шагналын “хур” буулгуулж санаа амардаг зуршил бий болов. Төрийн бүтэц-зохион байгуулалт, ажлын арга барил ийм байхад *төрийн захиргааны шинэтгэлийг* зориглон барьж авах улстөрийн нам, төрийн зүтгэлтэн гарч ирэхгүй л байна. Энэ бүхэн улстөрчдөөс, улстөрийн хошуучлагчдаас сэтгэл хөдлөл, мэдрэмж, дур зоргод дулдуйдсан үйл байдлыг бус, харин рациональ бодлогыг шаардаж байна.

Хөгжил дэвшлийн хөтөч болдог элитийн улстөрийн соёлд *эргэлт* гарахгүй бол ардчиллын тухай жирийн иргэдийн мэдлэг, төсөөлөл, итгэл үнэмшил, хандлага, сэтгэл зүй, санаа бодол ямархуу байх нь үндсэндээ ойлгомжтой. Нийгэмд шударга ёсны үнэлэмж улам буурч, үнэт зүйлийн хувьд хоёрдугаар зэрэгт тавигдах болсныг судалгаа сануулдаг. Ардчилал хөгжсөн орнуудад элитийн төдийгүй массын улстөрийн соёлын хүрээнд хариуцлагын ёс зүйд гойд анхаарах болсныг дахин тэмдэглэе. Хариуцлага юуны өмнө бид өөрсдийн итгэл үнэмшлээрээ зорьсон үйлдлээ хийх төдийгүй түүнээс гарч болох бүхий л үр дагаврыг нягтлахыг шаарддаг ажээ. Түүний дээр итгэл үнэмшлээ байнга шүүмжлэлтэй тунгаан үзэж, мухар сүсэг, гаднын зүсэн бүрийн тулгалт, нөлөөллөөс цэвэрлэж байх учиртай аж. М.Вебер итгэл үнэмшил, хариуцлагын ёс зүй хамтдаа жинхэнэ хүнийг, "улстөрийн авьяастай хүнийг" төлөвшүүлж, харилцан бие биеэ нөхөж байдаг тухай "Улстөр бол мэргэшил мөн" номондоо бичсэн байна.

Өнөө үед Өрнө, Дорнын соёлын уулзвар дээр монголын улстөрийн соёл өөрчлөгдөн төлөвшиж байна. Өрнийн ардчиллыг жишиг болгохдоо 1-рт, Өрнийн соёл иргэншил, түүний дотор ардчиллын үнэт зүйлс нь Сэргэн мандал, Реформац, Соён гэгээрүүлэлт, Аж үйлдвэрийн хувьсгалын бүхэл бүтэн түүхэн

үеүдийг дамжин боловсрон хөгжиж ирсэн; 2-рт, өрнийн улстөрийн ардчиллын онцлог нь хувь хүний эрх, эрх чөлөөг товойлгон тавьж, энэ ч чанараараа улстөрийг хувь шинжтэй, эрх мэдлийн төлөө хэсэг бүлгүүдийн ашиг сонирхлын зөрчил, хатуу ширүүн өрсөлдөөн талаас үндэслэх нь түгээмэл байдаг анхаарал татдаг. Харин Азийн ардчилал нь хамтын шинж, нийтийн хэрэгцээ, нийгмийн үүрэг, бүлгийн эв нэгдлийг дээдэлдэг, эрх мэдлийг зэрэг зиндаа, хүндэтгэл ёслолтой холбон үздэгээрээ ялгардаг. Зүүн Азийн орнуудын ардчилал өрнөтэй харьцуулахад иргэдээсээ илүү чанд сахилга, дуулгавартай байдлыг шаардаж тэд ч хүлээн авдаг онцлогтой байна. Энэ нь тухайн орнуудын ардчиллыг өрнийхөөс сүрхий дордуулчихсан зүйлгүй бөгөөд харин ч иргэд нь гэмт хэрэг, хүчирхийлэлгүй орчинд сэтгэл өөг аж төрөх бололцоотой ажээ. “Өнөөдөр Зүүн Азийнхан өөрсдийн эдийн засгийн гайхшруулсан хөгжлийг барууны соёлыг оруулж ирснээр биш, харин өөрийн уугуул соёлдоо үнэнч байдгаар тайлбарладаг. Тэд Өрнөтэй ижил болсондоо биш, харин ч түүнээс ялгаатай үлдсэнээ амжилт олсон гэж баталдаг”¹⁵ хэмээн С.Хантингтон цохон тэмдэглэжээ. Наад зах нь, ардчиллын өлгий-америкийнх гээд орой бүр телевизээр аллага, хүчирхийлэл дүүрэн кино үзүүлэх нь манай хүүхэд залуучуудын ёс суртхуунд байтугай америкчуудад өөрсдөд нь муугаар нөлөөлдөг ч юм билүү. Учир нь 100 мянган хүн тутамд ногдох хоригдлын тоогоороо энэ улс дэлхийд толгой цохидог гэдэг¹⁶. Иймээс бид хэдийгээр өрнийн ардчиллаас суралцаж байгаа ч бүхнийг сохроор хуулбарлалгүй, “уулын буга хараад унасан морио орхилгүй” үндэсний сэтгэлгээ, улстөрийн уламжлалаас үнэ цэнэтэй бүхнээ авч үлдэх нь бидэнд чухал байна. Чингэвээс монголын гэсэн ардчиллыг хөгжүүлж, улстөрийн соёлыг түүнийг батжуулан бэхжүүлэх хүчин зүйл болгож чадах билээ. “Ёс зүйгүй улстөрийн бодлого хүмүүсийн амьдралыг өөд татахгүй, ёс суртахуунгүй амьдрал хүмүүсийг амьтны зэрэгт аваачдаг бөлгөө”¹⁷. Учир иймд монгол үндэсний соёл, түүний улстөрийн соёлын ёс суртхуунлаг шинжийг товойлгон үзэж, ёс зүйтэй, шударга улстөрийг бий болгохоос ардчиллын зүгшрэл, хувь заяа хамаарах бөлгөө. Нэгэн нэрт сэтгэгч үндэсний ёс заншил, зан суртхууны чадавхийн тухайд “Хамгийн азтай газар зүйн байршил, хамгийн сайн хууль ч ноёлогч зан суртхууны хажуугаар үндсэн хуулийн оршин тогтнолыг хангаж чадахгүй бөгөөд харин зан суртхуунд түшиглэвээс хамгийн таагүй газарзүйн нөхцөл, хамгийн боловсронгуй бус хуулиудаас ч ашиг хүртэж болно”¹⁸ хэмээсэн байдгийг энд дурдсу.

Ер монгол төрхтэй улстөрийн шинэ соёл соёолох үр үндэс нь монгол ахуйгаас ургаж төлжсөн иргэн төртэйгөө, иргэд хоорондоо харилцах хэм хэмжээ, түүхийн сорилтыг даван туулсан төр ёсны дэвшилт ололтууд, үндэсний ардчилсан, иргэнлиг өв сан байх ёстой билээ. Өөрийн үндэсний сэтгэлгээ, эрхэмлэл, хүсэл зориг, үнэт зүйлст дулдуйдан гаргасан төрийн бодлого, шийдвэрийг иргэд дуртай хүлээн авч дэмждэг байна. Жишээ нь, хот-улсаа цэвэр цэмцгэр байлгахын тулд бохь захилахыг хориглосон тухайд америк судлаач, хэрэв америкчууд бол шуугиан дэгдээж болох байсан ч харин уг шийдвэрийг Сингапурт тайван хүлээж авч байсныг онцлон тэмдэглэсэн байдаг. Түүнчлэн Япон улс хувьдаа галт зэвсэг эзэмших эрхийг бүр 1588 онд хоригложээ.

Ардчиллын сүүлийн хагас зуун жилд энэ хориг өргөн дэмжлэг хүлээсэн хэвээр байгаагаар үл барам Бууны үндэсний нийгэмлэг нь 49 галт зэвсэг хувь хүний гар дээр байгаад сэтгэл дундуур байдаг ажээ.¹⁹ Эндээс үзэхэд манайд бохь, буу сэлтийг ор тас хориглодоггүй юмаа гэхэд нийгмийн дэг журам нь хувь хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулахад асар нөлөөтэйг иш үндэс болгож, ардчилсан нийгэмд ч иргэдийнхээ амь нас, аюулгүй байдлыг хангах талаар их ажил хийх шаардлага тулгарч байна. Чингэхдээ монголчуудын уламжлалт улстөрийн соёлын үнэт зүйл-хэм хэмжээ, нийтэч, эв зөийг хичээдэг, дэг журам, эрх чөлөөг эн тэнцүү үздэг, эрхээс үүргийг чухалчилдаг, бусдын эрх ашигт хүндэтгэлтэй ханддаг зэрэг сайн чанарт тулгуурлах нь дамжиггүй. Үүнээс үндэслэн харилцан ойлголцол, зөвшилцөл, итгэлцэл, хамтын ажиллагаа нь улстөрийн нийгэмшлийн бодитой шалгуур төдийгүй хайрлаж хямгадууштай “нийгмийн капитал” гэдгийг санах хэрэгтэй.

Монголын нийгмийг ардчиллах үйл явц алгуур боловч ахиж байна. Нийгэмд улстөрийн үндсэн институтууд, үнэт зүйлс болон улстөрийн тоглоомын дүрмийн талаар улстөрийн хүчнүүд, иргэд харилцан зөвшлийн тодорхой төвшинд хүрсэн нь улстөрийн соёлын төгөлдөршлийн нэг ололт мөн. Хэрэг дээрээ улстөрийн үйл явцын нөлөө бүхий бүх тоглогчид улстөрийн ардчилал, зах зээлийн эдийн засаг, эрх зүйт төрийг санаа нэгтэй хүлээн зөвшөөрсөн гэсэн үг. Гэвч энэ нь одоогийн нийгэмд ардчилсан гэсэн тодотголтой улс төрийн соёл бүрэн боловсорчээ, улстөрийн соёлын онолч Алмондын үздэгээр “иргэний”, эсвэл “оролцооны” хэв маягтай болжээ гэж хэлэхэд учир дутагдалтай. Улстөрийн соёлын төлөвшлийн өнөөгийн шатанд шилжилтийн шинж давамгайлж байгаа нь илт бөгөөд харин түүний цаашдын хувьсал өөрчлөлт, чиг хандлагыг нь барин тавин төлөгчлөх нь бэрхшээлтэй. Гэхдээ нэг зүйл тодорхой байна. Ардчилсан үзэл санаа монголын нийгмийн ухамсар, улстөрийн соёлд “диффузи” хэлбэрээр нэвтрэн тархсан нь үнэн. Одоо олон түмний дотоод итгэл үнэмшил, үйл байдал болж хувирах учиртай. Хэдийгээр улстөрийн ухамсар, үзэл санаа бие даасан шинжтэй ч материаллаг хүч түүнийг тэтгэж “тэжээж” байдаг жамтай. Учир иймд гагцхүү ард олны амьжиргаа сайжирснаар л ардчилал ард түмний итгэлийг баттай хүлээж, ардчилсан соёл зүгширч төлөвших болно. Хэрэв дараагийн 20 жилд хүмүүсийн аж амьдрал өмнөх 20 жилийн жишгээр үргэлжилвээс, дээрээс нь хууль тогтоомж, ёс суртхуун, хариуцлагын ёс зүй хөсөр хаягдсан хэвээр байваас монголд ардчилал утопи болж үлдэнэ гэсэн таамаг дэвшүүлэхээс арга үгүй. Улстөрийн соёл улстөрийн системийн тогтвортой байдлыг хангах субъектив хүчин зүйл байж ч чадахгүй. Өнөөгийн шилжилтийн үеийн энэхүү “хаос” ямаршуу үр дагавартайг Платон “Энэ нь (ардчилал- Ё.Д.) хамгийн шилдэг төрийн байгуулал бололтой. Өнгө алаглуулан нэхсэн бөс даавуу мэт зүсэн бүрийн ааш араншин эрээлжлэн сүлжилдсэн эл байгуулал бүгдээс гоё сайхан мэт... Ардчилсан улсад чи хэдийгээр чадалтай байвч удирдах хэрэгт оролцох ямарч шаардлагагүй, хэрэв чи эс хүсвэл заавал захирагдах ч албагүй...төрийн ийм байгууллын үед цаазын ял сонссон юмуу, эсвэл нутаг заагдсан хүнийг яах ч үгүй өнгөрөөдөгөөс тэр этгээд эргэн ирж нийгэм дотор үйл хэргээ үргэлжлүүлнэ. Энэ нь хэнд ч падгүй,

хэн ч түүнийг үл анзаарах мэт тул ийм хүн сэтэрлэгдсэн лугаа зугаацах бөлгөө. Гэтэл ардчилсан төрийг түүний өөрийнх нь эрхэмлэн дээдэлж, хүсч тэмүүлсэн эрх чөлөө, тодруулж хэлбэл, хэрээс хэтэрч, засаг захиргаагүй, эмх замбараагүй байдал болж хувирсан эрх чөлөө сүйрэлд хүргэнэ. Хүмүүс ч, ардчилсан төр ч хэмжээ хязгааргүй эрх чөлөөнд ухаанаа алдтал согтож мансуурна”²⁰ хэмээн дүрслэн өгүүлжээ. Эдүгээ интеграл улстөрийн соёлын талаар ярих нь эрт бөгөөд учир нь улстөрийн соёлын янз бүрийн элементүүд, дэд соёлууд зүгшрэн, хоорондоо шүтэн барилдсан харилцан хамааралтай бүхэллэг систем болж чадаагүй байна. Тухайлбал, хот-хөдөөгийн, ахмад-залуу үеийн, эмэгтэйчүүдийн, элит-массын гэх мэт хоорондоо ялгаа, зөрчил бүхий улстөрийн дэд соёлууд бий. Улстөрийн соёл төгөлдөршихийн хэрээр ардчиллын бэхжилт, улстөрийн тогтвортой байдлыг хангах чухал нөхцөл бүрдэх болно. Ардчилсан институт, ардчилсан улстөрийн соёлын аль аль нь ардчилсан улстөрийн системд хүргэх арга зам болно.

Эдүгээ манай улстөрийн систем албат-авторитар соёлын хэв маягаас оролцооны улстөрийн соёлд шилжиж байна. Иргэд эрх баригчдын заалтыг идэвхгүй гүйцэтгэгчид байж, улстөрийн шийдвэр боловсруулах үйл явцын гадна байсан бол одоо хууль тогтоомжийг биелүүлэх үүрэг хүлээгээд зогсохгүй, төрийн бодлого шийдвэрийг шүүн хэлэлцэх, санал оруулах, хэрэгжилтийг хянах боломж харьцангуй нээлттэй болов. Гэвч олон түмэн оролцооны улстөрийн соёлын зах зухаас дөнгөж сурч эхэлж байна. Энэ бол цаг хугацаа, хүчин чармайлт, тэвчээр шаардах үйл явц гэдэг нь тодорхой. Бидний зорилго хүн төрөлхтний хөгжлийн хандлага, ардчиллын үнэт зүйлсийн хүрээнд монголын улстөрийн сэтгэлгээний уугуул төрх, олон зуун жилээр хуримтлагдан уламжлагдсан оюуны их баялаг, ёс зүйн соёлыг суурь болгож үнэтэй цэнэтэй бүхнээ сэргээж хадгалж улстөрийн орчин цагийн соёлоо бүрдүүлэхэд оршиж байгаа билээ. Харин тэрхүү соёл хэзээ төлөвшин бий болох вэ гэвэл улстөрийн элит, олон түмэн, нам эвсэл холбоод ардчилсан үзэл санаа, үнэт зүйлсийг дотоод итгэл үнэмшлээ болгож, нийтээр нэгэнт хүлээн зөвшөөрч дагаж мөрддөг улстөрийн тоглоомын дүрмийг ягштал баримталдаг болсон тэр цагт л биеллээ олно гэж хэлэх байна. Улстөрийн соёлыг авч үзэхэд хүссэн хүсээгүй улстөрийн нийгэмшлийн асуудал хөндөгдөх болно. Улстөрийн нийгэмшил нь улстөрийн шинэ соёл бүрэлдэж бий болох арга зам юм. Энэ нь нэн адармаатай, ялангуяа хувь хүний хувьд дээр хэлсэнчлэн “зовлон зүдгүүртэй” үйл явц байдаг. Уул үйл явцад гаднын хүчин зүйлийн, тухайлбал, улстөрийн нийгэмшлийн агентуудын нөлөө үлэмж хүчтэй байдгаараа онцлог. Жишээ нь, нийгмийн сэтгэл зүй, олон нийтийн санаа бодлыг хэвлэл мэдээллийн хэрэгсэл бараг дангаараа “жолоодож” элдэв төрлийн манипуляци хийхэд өнөөгийн улстөрийн орчин нээлттэй байгаа нь нууц биш. Иймд хүмүүс хоорондын харилцааны улстөрийн коммуникацийн “амьд” хэлбэрүүд чухал үүрэгтэйг судлаачид тэмдэглэсээр буй. Мэдээлэлд “хахсан” эрин цагт иргэд улстөрийн мэдээллийн бэлэн хэрэглэгчид биш, харин тэр дотроос бодитой үнэн зөвийг нь шилж сонгогчид байх шаардлагатай. Энэ бүхэн улстөрийн нийгэмшилд төрийн бодлогоор нөлөөлөх, түүний агентуудын үйл

байдлыг судалж, зохицуулж чиглүүлэх нь шинэ улстөрийн соёлд чухал гэдгийг сануулж байна.

Эцэст нь тэмдэглэхэд аль ч соёлд нэгэн адил эрх зүйн засаглал, хуулийн хариуцлага, засаг төрийн байгууллагуудын шаргуу үйл ажиллагаа, ёс зүйн хүчин зүйлийг онцлон анхаарахгүй бол ардчиллах үйл явц нь эрх, эрх чөлөө, эрх зүйт төрийн тухай хоосон ярианаас хэтэрдэггүй ажээ. Ардчилал, хүний эрх, эрх чөлөөг мушгин гуйвуулж дур зорго болгон хувиргаж болохгүй. Хүнд суртал, хүний хууль ёсны эрхэнд халдсан өчүүхэн төдий ч илрэлтэй шийдвэртэй тэмцэх нь зүйн хэрэг. Үүний тулд хууль цаазат төр, хүчирхэг иргэний нийгэм, зөв шударга хууль, өндөр ёс зүй хэрэгтэй. Ардчилалд цор ганц загвар байдаггүйн адил ардчилсан улстөрийн соёл гэвэл заавал тийм байх ёстой гэсэн хатуу жор бас байхгүй. Онолын ерөнхий хүрээ, үндсэн зарчмууд л байна. Дээр дурдсан Зүүн Азийн орнууд өвөрмөц ардчиллын загварыг бий болгосны нэг адил өөрийн онцлогтой ардчилсан улстөрийн соёлыг бүрдүүлснийг хүлээн зөвшөөрдөг. Бид ч ийм л замаар явах буйзаа. Хариуцлагатай төр бол ёс зүйтэй төр, ардчилсан улстөрийн соёл бол ёс суртхуунлаг соёл байх учиртай.

Ном зүй

1. Довчин Ё. Степная политическая культура. СПб., 2000. с.26-28, 55-59.
2. Насилов А.Д. 18 степных законов - памятник монгольского феодального права XVI-XVII вв. Л.,1987.с.12.
3. Уолкер С.С. Чингиз-хан. Ростов-на Дону. 1998.с.37.
4. Pye.L. 1985. Asian Power and Politics. The Cultural Dimensions of Authority. p.20.
5. Pye.L. Ibid. p.22.
6. Алмонд Г. Верба С. Гражданская культура и стабильная демократия. //Полис.,1992. № 4. с.129.
7. Тойнби А. Постигание истории. М., 1996. с.153.
8. Рерих. Живая этика. Община. Л., 1993. с.250.
9. Даш-Ёндон Б. Орчин үеийн монголын нийгмийн хүмүн бүтэц,оюуны амьдралын тухайд. "Манай монгол" сэтгүүл. 1999.№ 2. 17 дахь тал.
- 10."Шинэ толь". 1994. Тусгай дугаар. 19-20 дахь тал.
11. Dalton R. Comparative Politics:Micro-behavioral Perspectives.1996. A New Handbook of Political Science. Ed.by Goodin R.and Klingemann H. Oxford. p. 347.

12. Капустин В.Г. Демократия и справедливость. // Полис.,1992. № 1-2. с.93.
13. Rawls. J. 2005. A Theory of Justice. Reprint. Harvard University Press. p.7.
14. Habermas. J. 1993. The Tasks of a Critical Theory / Readings in Social Theory. The Classic Tradition to Post-Modernism. ed. by J.Farganis. McGraw-Hill. p.351.
15. itics.96/97.Guilford. p. 227.
16. Slann M.1998. Introduction to Politics. Governments and Nations in the Post Cold War Era. McGraw-Hill., p.62.
17. Далай-лама XIV. Буддизм Тибета. Нартанг. 1991.с.81.
18. Токвиль А. де. Демократия в Америке. М., 1992.с.22.
19. Slann M. Ibid. pp. 58-59.
20. Платон. Собр.соч.,Т.3. М.,Мысль. 1994.с.344, 350.

Abstract

The author reviews empirical and theoretical works on the role political culture in politics. It seeks to clarify some specific features of mongolian political culture and explores the ways in which the descriptions of power relationships in accordance with political culture, especially ethical and value-based aspects. The text discusses political behaviour of elite in the democratic transitional period and is concerned particularly with the majority principles of democracy and the notion of popular rule. It attempts to describe some causal factors concerning with the decline of confidence in political institutions and political cynism. The author points out that political culture is main axis of modern political legitimacy shedding light on largely hidden aspects of the challenges to democratic political process.